



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 11/209

Улаанбаатар хот

“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын  
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/761 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, эзэмшигч байгууллагад нь сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн нийт 1,345,875,000 (нэг тэрбум гурван зуун дөчин таван сая найман зуун далан таван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслүүдийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ (О.Ганбаатар)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар худалдан борлуулж зохих дансанд нь орлого болгон авахыг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ (О.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ (О.Ганбаатар)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000927



Нийслэлийн Өмчийн Ашиглалт, Удирдлагын Газрын даргын 2021 оны... дугаар сарын... өдрийн... дугаар тушаалын хавсралт

СЭЛБЭГИЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛУУЛАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАСГААЛТ

№	Байгууллагын нэр	Автомашини марк, улсын дугаар	Үйлдвэр-лэсэн /Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэрлэсэн өнгө	Гүйлт /км/	Балансын үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл
1		Эжобус J-800Т 23-73 УБС	2014/2015	Зорчигч тээврийн автобус, МОНГОЛ, Ногоон	187209	269,175,000	257,959,375.23	11,215,624.77	Зорчигч тээврийн зориулалттай тээврийн хэрэгслүүд нь 150 мянгаас 204 мянган км явсан, техникийн комиссын дүгнэлтээр явах эд анги элэгдсэн, карказ зэвэрч муудан рам хугарсан, урд тэнхлэг эвдэрч хөдөлгүүрийн түлш, маслын зарцуулалт ихэссэн, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд алдагдалтай сэлбэг олдохгүй, техникийн талаас хөдөлгөөнд оролцоход тэнцэхгүй тул ашиглалтаас хасаж сэлбэгээр ашиглах хүсэлт ирүүлсэн.
2		Эжобус J-800Т 92-37 УНК	2014/2015	Зорчигч тээврийн автобус, МОНГОЛ, Ногоон	179065	269,175,000	257,959,375.23	11,215,624.77	
3	"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ	Эжобус J-800Т 25-79 УБС	2014/2015	Зорчигч тээврийн автобус, МОНГОЛ, Ногоон	151231	269,175,000	257,959,375.23	11,215,624.77	
4		Эжобус J-800Т 24-94 УБС	2014/2015	Зорчигч тээврийн автобус, МОНГОЛ, Ногоон	204380	269,175,000	257,959,375.23	11,215,624.77	
5		Эжобус J-800Т 74-37 УНК	2014/2015	Зорчигч тээврийн автобус, МОНГОЛ, Ногоон	182396	269,175,000	257,959,375.23	11,215,624.77	
Нийт дун						1,345,875,000	1,289,796,876.15	56,078,123.85	